Багануур үйлдвэрлэл, технологийн парк
ОНӨТҮГ-ын 2022 оны 03 дугаар сарын 15-ны
өдрийн ... дугаар албан бичгийн хавсралт

# “ХОТЫН ИРГЭНИЙ ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2022 оны ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2022 оны 12 дугаар сарын 09 Багануур дүүрэг

| Заалтын дугаар | “Хотын иргэний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ | “Хотын иргэний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагаа | Зохион байгуулсан ажлын биелэлт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|
| ХОЁР. ХОТЫН СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | |
| 1 | Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах, хяналт тавих зохицуулалтыг боловсронгуй болгох, үйл ажиллагааны нээлттэй байдлыг нэмэгдүүлж, авлига үүсгэх эрсдэлийг бууруулах | Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэдэд нээлттэй хүргэх | Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах, хяналт тавих үйл ажиллагааны нээлттэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор www.baganuur-itp.mn цахим хуудсаар дамжуулан иргэдэд болон хөрөнгө оруулагчдад хүргэх мэдээллийг тухай бүр байршуулж байна. 2022 он гарсаар 60 орчим мэдээллийг байршуулав. Үүнд: Монгол Улсын бодлогын баримт бичигт тусгагдсан холбогдох заалтын хэрэгжилт, болон бусад арга хэмжээ, үндэсний хөтөлбөрүүдийн аян зэрэг мэдээ мэдээллийг иргэдэд хүргэж байна. | “Үр дүнтэй”-100% |
| 2 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын болон нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдад зориулсан заавал болон сонгон суралцах сургалтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх | Албан хаагчдын сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | - Төрийн албан хаагчдад зориулсан 2022 оны сургалтын төлөвлөгөөг нийслэл, дүүргээс зохион байгуулагдах төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалт, мэргэшүүлэх сургалт, ажлын байранд зохион байгуулах сургалт гэсэн үндсэн 3 зорилтын хүрээнд төлөвлөж батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Нийт сургалт, семинар зөвлөгөөний тоо-16<br>Ажлын байран дахь сургалт-8<br>Мэргэшүүлэх сургалт-2 | “Үр дүнтэй”-100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Туршлага солилцох арга хэмжээ -2<br>Бусад -4<br>Хамрагдсан нийт албан хаагчдын тоо-64<br>Эмэгтэй албан хаагч-38<br>Эрэгтэй албан хаагч-26<br>Удирдах албан тушаалтан-5<br>Гүйцэтгэх, туслах албан тушаалтан-59<br>Нийт албан хаагчдад эзлэх хувь -90%<br>2022 онд байгууллагын албан хаагчид ажил үүргийн чиглэлийн дагуу цахим сургалтад 3 удаа ба бусад хэлбэрийн сургалтад нийт давхардсан тоогоор 60 гаруй албан хаагчид хамрагдаад байна. Мөн ажлын байранд практик сургалтуудыг явуулж байна. Үүнээс гадна 2022 он гарсаар Авлигатай тэмцэх, жендэрийн эрх тэгш байдал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, зэрэг үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр нөлөөллийн зурагт хуудсыг байгууллагын цахим хуудас болон албан хаагчдын хувийн фейсбүүк хуудсаар дамжуулан сурталчлах нөлөөллийн арга хэмжээ авч танилцуулга, мэдээлэл өгч ажиллаж байна.<br>- Хэрэгжилт 100% | |
| ГУРАВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | |
| 3 | Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Багануур үйлдвэрлэл, технологийн парк, Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк, Багахангай үйлдвэрлэл, технологийн паркуудын дэд бүтцийг байгуулах | Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 110кВ-ын 6,76км урт өндөр хүчдэлийн агаарын шугамыг барих | Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 6,76 км урт 110 кв-н агаарын шугамыг барих зураг төслийн нийт төсөв 3922,0 сая. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд МЕСЕС ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулснаар тус компани 1748,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хариуцах бөгөөд, Нийслэлийн төсвөөс 2174,0 сая төгрөг баталсан. Үүнээс 2022 онд 1174,1 сая, 2023 онд шилжих төсөвт 1000,0 сая төгрөг баталсан. Төсвийн хэмнэлтийн хуулийн хүрээнд хийсэн Нийслэлийн 2022 оны төсвийн тодотголоор 2022 оны батлагдсан төсвөөс 500,0 | “Үр дүнтэй”-100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | саяыг хасаж 2023 оны шилжих төсөврүү шилжүүлэхээр НИТХ-р шийдвэрлэсэн. Гүйцэтгэгч сонгон шалгаруулалтаар Энх Өглөө ХХК 2022 оны 9 сарын 5 өдөр НЗДТГ-тай гэрээ байгуулан бүтээн байгуулалтыг эхлүүлснээр зураг төслийн трассын дагуу өгөгдсөн координатуудаар улаан шугам татаж, тулгууруудын байрлалыг тодорхойлж, тулгуур босгох 40 суурийн барилга угсралтын ажлуудыг гүйцэтгэж, 2022 оны 674,1 сая төгрөгийн төсөвтэй Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээт ажил бүрэн хийгдэж дууссан.<br>МЕСЕС ХХК-ий зүгээс 526,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар суурийн барилгын ажил хийж, 500.0 сая төгрөгийн бетон болон төмөр тулгуур бэлтгэх ажил хийсэн байна<br>Хэрэгжилт 100% | |
| ДӨРӨВ. АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | |
| 4 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд айл өрх, ААНБ-ыг идэвхтэй оролцуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, арчлалт хамгаалалтын менежментийн ажлыг сайжруулах | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд албан хаагчдыг тус чиглэлийн сургалтад хамруулах, байгууллагын дундын хуримтлал үүсгэн, дүүргээс өгөх чиглэлийн дагуу хуваарьт газар мод тарих ажлыг зохион байгуулах | - 2022 оны 5 дугаар сард болон намар 10 дугаар сард мод тарих бүх нийтийн хөдөлгөөнд байгууллага хамт олноороо идэвхтэй оролцож тухайн үеийн тайлан мэдээг холбогдох газар, хэлтэст хугацаанд нь хүргүүллээ.<br>- Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд албан хаагчдыг чадавхжуулах, мод тарих, арчлах чиглэлийн анхан шатны ойлголтыг өгөх зорилгоор 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Багануур дүүргийн Захирагчийн ажлын алба,, Нийслэлийн Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ-тай хамтран зохион байгуулсан “Мод тарих арга технологи, арчлах аргачлал”-ын сургалтад Үйлдвэрлэл, технологийн албаны Ахлах мэргэжилтэн, Үйлдвэрлэл, технологийн кластер инженер нар хамрагдсан. | “Үр дүнтэй”-100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | - Байгууллагын дундын хуримтлал үүсгэн 05-06 дугаар сард дүүргээс өгөх чиглэлийн хүрээнд хуваарьт газар мод тарих үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн.<br>Мөн иргэдийг ахуйн хог хаягдлаар бордоо хийх аргачлалд сургах, эко хэв маягийн мэдлэгтэй болгох, цаашид бордоог мод тарилтад ашиглах зорилгоор цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан байгууллагын цахим хуудсаар ахуйн хог хаягдлаар бордоо хийх орц, найрлагын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэн ажиллаж байна. | |
| ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙГ АНХААРАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | |
| 5 | “Илүүдэл жингүй – Эртэч Монгол” хөдөлгөөнийг дэмжих аяныг зохион байгуулах | Албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, эрүүл хэв маягт төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах | Албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх үүднээс ажлын байранд өдөр бүр 2 удаа 10-15 минутаар дасгал хөдөлгөөнийг хийж хэвшсэн.<br>Мөн байгууллагын албан хаагчдаас өглөө эртлэн алхах болон фитнесс дасгалд явах зэргээр Эртэч Монгол” хөдөлгөөний хүрээнд өөрсдийн эрүүл мэндийг дэмжин зөв дадал хэвшил тогтооход анхаарч байна.Улаанбаатар марафонд нэгдэцгээе Нийслэлийн Засаг даргын нэрэмжит цомын аянд нэгдэн оролцлоо.Мэдээ тайланг хүргүүлэв | “Үр дүнтэй”-100% |

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.МӨНХТОГТОХ